



**БАГАНУУР ДҮҮРГИЙН
БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК ОНӨААТҮГ
ДАРГЫН ТУШААЛ**

2019 оны 10 сарын 24 өдөр

Дугаар А/32

Улаанбаатар хот

**Үр дүнгийн болон ур чадварын
урамшуулал олгох тухай**

Хөдөлмөрийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.1 дэх хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтын 2.2 дахь хэсэг, 2018 оны 382 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралт, “Багануур үйлдвэрлэл, технологийн парк” ОНӨТҮГ-ын дүрмийн 5 дугаар зүйлийн 5.1.5, 5.1.8 дахь заалт, “Багануур үйлдвэрлэл, технологийн парк” ОНӨТҮГ-ын Дотоод журмын 9 дүгээр зүйлийн 9.5, 9.6 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Албан хаагчдын 2019 оны эхний гурван улиралд хийсэн ажлын гүйцэтгэл, үр дүнг шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлэн үр дүнгийн урамшуулал олгосугай.
2. Үр дүнгийн болон ур чадварын урамшууллыг хавсралтад заасан хувиар бодож олгохыг нягтлан бодогч /Л.Оюунцэцэг/-д зөвшөөрсүгэй.
3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргааны албаны Ахлах мэргэжилтэн /Б.Мичид-Эрдэнэ/-д даалгасугай.

ДАРГА



Ч.ЭЛБЭГСАЙХАН